

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12 Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ДДЦС	Дарханы Дулааны Цахилгаан Станц
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНТУУЛ ТАНАА

2020.03.13 № 06/353
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дарханы Дулааны сүлжээ ТӨХК 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Д.Гантуул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашигладаггүй биет бус үндсэн хөрөнгүүдийг актлах, дахин үнэлэх арга хэмжээ авах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 03-наас 2020 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Их Наяд Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Их наяд аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/118 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК нь “Дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшилж, дулааны эрчим хүчийг хамгийн бага алдагдалтайгаар түгээж, хэрэглэгчээ дээдэлсэн чанартай үйлчилгээ үзүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах;
- Барилга угсралт, гадна дотор дулаан ус, цахилгаан хангамжийн угсралт, засвар;
- Хэмжих хэрэгслийг засварлах суурилуулах, худалдах;
- Гадаад худалдаа;
- Зуух даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, хийцийн үйлдвэрлэлт;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор дулааны үнэ тариф шинэчлэгдсэн;
- Томилолтын зардал шинэчлэн батлагдсан;
- Бүтэц орон тоо, цалингийн жишиг, нэмэгдэл шинэчлэгдсэн батлагдсан;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулсан;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд хөнгөлөлтийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ноён” программ хангамж ашигладаг байна.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн 1 хувиар тооцон 91.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 100.4 сая төгрөгөөр тогтоосон нь эрсдэлийг дунд гэж үнэлэн 2019 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлаас тооцсонтой холбоотой болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,052.8 сая төгрөгөөр буюу 28 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	155.0	88.1	-66.9
Авлага	815.5	1,480.9	665.4
Бараа материал	477.9	507.0	29.1
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	32.3	145.9	113.6
Үндсэн хөрөнгө	36,306.7	41,198.7	4,892.0
Хуримтлагдсан элэгдэл	-17,133.2	-16,733.2	-400.0
Биет бус хөрөнгө	1,007.0	1,050.7	43.7
Хуримтлагдсан элэгдэл	-57.0	-81.0	-24.0
Нийт хөрөнгийн дүн	21,604.2	27,657.1	6,052.9
Өглөг	1,173.4	1,537.9	364.5
Урьдчилж орсон орлого	49.6	355.2	305.6
Өр төлбөрийн дүн	1,223.0	1,893.1	670.1
Өмч: Төрийн	9,599.2	9,599.2	0.0
Нэмж төлөгдсөн капитал	6.9		-6.9
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915.9	2,915.9	0.0
Өмчийн бусад хэсэг	4,000.3	9,170.1	5,169.8
Хуримтлагдсан ашиг	3,858.9	4,078.8	219.9
Эздийн өмчийн дүн	20,381.2	25,764.0	5,382.8
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	21,604.2	27,657.1	6,052.9

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 66.9 сая төгрөг буюу 56.8 хувиар буурсан нь авлага барагдуулалт хангалтгүй байгаатай холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 665.4 сая төгрөгөөр өссөн нь 2018 оны 11 дүгээр сард аж ахуйн нэгж байгууллагын дулааны тариф 10.0 - 15.0 хувь нэмэгдсэн, айл өрхийн дулааны үнэ тариф 2019 оны 06 дугаар сарын 01-ээс 10.0 хувиар нэмэгдсэн нь төлбөрийн чадваргүй хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн, 2018-2019 онд шүүхийн байгууллагад 32 хэрэглэгчийн 49.5 сая төгрөгийн авлага барагдуулахаар хандсан ч 13 хэрэглэгчийн 8.0 сая төгрөг барагдсан байна. Орон сууцны зоорийн давхарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд төлбөрөө төлөөгүй 4-7 жил болсон /ТУЗ-д 21 хэрэглэгчийн 42.6 сая төгрөг найдваргүй авлагын судалгаа гаргаж танилцуулсан боловч дэмжигдээгүй/ авлага байна.

Дансны авлага өмнөх оноос 263.2 сая төгрөг, татвар, нийгмийн даатгалын авлага 2.5 сая төгрөгөөр буурсан, бусад богино хугацаат авлага 404.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж байгууллагаас авах нийт 449.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд “БТДН” ХХК-с авах 235.9 сая, “Жинсийн орой” ХХК-с 190.5 сая, “Дэлхийн зөн” ОУБ-с 9.4 сая, “Газар буудай”, “ХААНБанк”, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” гэрээт ажлын үлдэгдэл гэрээний дагуу 3 жилийн дараа төлөгдөх 10.4 сая, “Хур хөлөг” ХХК-с авах 2.0 сая төгрөгийн авлага тус тус байна. Эрчим хүчний тухай хуулийн дагуу төлбөрөө төлөөгүй хэрэглэгчдэд 54.8 сая төгрөгийн алданги тооцсон ба бусад авлагыг өсгөж, найдваргүй авлагын нөөц сангаас шүүхийн тогтоолоор 6.8 сая төгрөг хасагдаж 69.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бусад авлагыг энэ хэмжээгээр бууруулж харагдуулж байна.

Хувь хүмүүсээс авах авлагад ажлаас халагдсан ажиллагсдаас 1.6 сая төгрөгийн утасны төлбөрийн авлага, хувь хүнтэй хийсэн гэрээт ажлын санхүүжилтийн үлдэгдэл 15.5

сая төгрөгийн авлагыг хуулийн зөвлөхөд гэрээ дүгнүүлэх болон шүүхэд шилжүүлэхээр саналаа өгсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29.0 сая төгрөгөөр өсөхөд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар солигдсон Дархан хотын к14-27 дугаар цэг хүртэлх 2.6 км шугам шинэчлэлтийн ажил хийсэнтэй холбогдуулан хуучин акталсан ТӨБЗГ-н шийдвэрийн дагуу зарцуулах ф630 шугамыг эргэлтийн хөрөнгөнд 23.0 сая төгрөгөөр бүртгэсэн нь нөлөөлсөн байна. Дулааны төлбөртэй хэрэглэгчдээс компанид шаардлагатай бараа материалыг бартераар авсан ба худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаж, худалдан авалт хийгдсэн зарим нэг материалын зарцуулалт хийгдээгүй /энэ нь болзошгүй гэж төлөвлөгддөг/ зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,891.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 571.1 сая төгрөг, өөрөө үйлдвэрлэсэн 830.0 сая төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 5,169.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 1,678.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасагдсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө 43.7 сая төгрөгөөр өссөн нь программ хангамж худалдаж авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 670.1 сая төгрөгөөр өссөн нь авлага оны эхнээс 665.5 сая төгрөгөөр өссөн буюу авлага барагдуулалт муу байгаагаас өр төлбөрийг барагдуулах эх үүсвэр бага байгаатай холбоотой. Богино хугацаат өглөг "ДДЦС" ТӨХК-д өгөх өр 77.4 сая, төсөвт төлөх төлбөр 92.4 сая, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлөх төлбөр 139.5 сая, банкны богино хугацаат зээл 55.2 сая, урьдчилж орсон төлбөр 305.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Тайлант оны 7-р сард эргэлтийн хөрөнгөнд зориулж 500.0 сая төгрөгийн зээл авсан ба зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу 2020 оны 7 дугаар сард төлж барагдуулахаар байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 5,382.8 сая төгрөгөөр өссөн нь өмчийн бусад хэсэгт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам шинэчлэлтийн ажлын 4,549.6 сая, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн хүрээнд бий болсон нийт 620.1 сая төгрөгийн 13 нэр бүхий хөрөнгийг тус тус ТӨБЗГ-ын 2019 оны 283, 274 дүгээр тогтоолыг үндэслэн бүртгэсэн нь шалтгаалжээ. Энэ нь компанийн хөрөнгийг нэмэгдүүлж байгаа хэдий ч ашиглалтын зардал болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг нэмэгдүүлж ашиг алдагдалд нөлөөлж байна.

Мөн нэмж төлөгдсөн капитал 6.9 сая төгрөгөөр буурсан ба хуримтлагдсан ашиг тайлант үеийн 219.9 сая төгрөгийн ашгаар өссөн байна.

2.9 Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний яамны шийдвэрээр Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг 9,443.0 сая төгрөгийн орлоготой, 9,774.0 сая төгрөгийн зардалтай, 331.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталжээ.

Тайлант жилд баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 9,443.0 сая төгрөгийн нийт борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөснөөс 10,289.2 сая төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөөг 108.9 хувиар давсан нь дулааны үнэ тариф өссөнтэй холбоотой байна.

Нийт 9,991.2 сая төгрөгийг зарцуулж, зорилтот түвшний төлөвлөгөөний зардлаас 217.2 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна. ДЭХ-ний зардал 72.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 144.4 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гэрээт ажлын зардалтай шууд холбоотой байна.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК нь тайлант онд 249.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 580.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж ашигтай ажилласан байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 1 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн нийт 90.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авлагын дансыг тусгайлан авч үзэх нь чухал гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар 76, хөрөнгийн урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн талаар 26, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар 114, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд мэдэгдлийн талаар 13, нийт 229 мэдээллийг боловсруулан хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 421.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 50 хувьтай буюу 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хуульд заасны дагуу хугацаанд нь төлж барагдуулах гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 90.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 100.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Дарханы Дулааны сүлжээ ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант жилд төлөгдөөгүй авлагын нийт 155.3 сая төгрөгийн 2 авлагын дансанд НБББББ-ын дагуу 62.1 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь Байгууллагын мөрдөж байгаа "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн хугацаа хэтэрсэн авлагын найдваргүй авлагын нөөц байгуулах тухай заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн байдлын тайланд авлага данс цэвэр боломжит үнэ цэнээр тусгагдахгүй буруу илэрхийлэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын мөрдөж байгаа "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн дагуу хугацаа хэтэрсэн авлагыг тооцож найдваргүй авлагын нөөц байгуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Манай компани 2017-2018 онуудад найдваргүй авлагын нөөц санг 81.5 сая төгрөгөөр байгуулсан хэдий ч авлагаас 11.6 сая төгрөг хасагдаж нөөц сангийн үлдэгдэл 69.9 сая төгрөг байна. Найдваргүй авлага гэж үзсэн хэрэглэгчийн талаар шүүхэд материал бүрдүүлж өгч байгаач шийдвэрлэх хугацаа урт, материал нь буцаагддаг, ТУЗ-д танилцуулагдаад шийдвэрлэгдээгүй зэрэг асуудлаас шалтгаалж нөөц сан дахин байгуулах хугацааг 2021 он хүртэл хойшлуулаад байна.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Авлагын 3 сая төгрөгөөс дээш үлдэгдлийг түүвэрлэн шалгахад 5 байгууллагатай 19.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “оршин байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн байдлын тайлан тайлан буруу илэрхийлэгдэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Холбогдох газруудтай тооцоо нийлэх ажлыг зохион байгуулна.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.2 Илрүүлэлт:

Бараа материалын 2.4 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ 1 байгууллагаас зардлын баримттай, ибаримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1 “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байдал”, “бодитой оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.3 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтыг дутуу бүрдүүлж зардал гаргах;

3.3.4 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг тогтоосон хугацаанд шаардан гаргуулж, иж бүрэн баримт бүрдүүлж гүйлгээ хийж байх;

3.3.5 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

НӨАТ төлөгч компанитай худалдан авалт хийхдээ и-баримтаар НӨАТ-н баримтыг заавал шивүүлж бүртгэл тооцоонд тусгадаг. Энэ компанитай шууд худалдан авалт хийсэн ба НӨАТ төлөгч компани биш байсан тул и-баримтаар шивсэн эсэхийг тодруулаагүйгээр зарлагын баримтаар бүртгэл хөтөлж, төлбөр тооцоог банкны харилцах дансдаар хийсэн. Цаашид зөвлөмжийн дагуу и-баримтаар худалдан авалт хийж хэвшүүлнэ.

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.2 Илрүүлэлт:

Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 2 нэр төрлийн 6.7 сая төгрөгийн биет бус хөрөнгийг данснаас хасах, дахин үнэлэх арга хэмжээ аваагүй байна нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “оршин байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4.3 Эрсдэл:

Санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгө (биет бус хөрөнгө)-ийн дүнд ашиглахгүй байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн дүнгээр өсөж харагдах;

3.4.4 Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах, дахин үнэлэх асуудлаа тухай бүрд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж зохих шийдвэр гаргуулж байх;

3.4.5 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Төсвийн 2 программ 0.8 сая төгрөг, санхүүгийн болон дуудлагын программ нь 5.9 сая төгрөг энэ нэр төрлийн программ тайлант оны 12-р сард элэгдлээ бүрэн нөхөж дууссан болно. Иймд 2020 оны хөрөнгө данснаас хасах, актлах журмын дагуу холбогдох ажлыг зохион байгуулан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	155,047,732.39	88,075,703.12
1.1.2	Дансны авлага	736,440,724.67	1,001,258,907.18
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	2,645,657.71	75,828.66
1.1.4	Бусад авлага	76,365,418.87	479,583,866.08
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	477,930,106.31	506,974,650.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	32,278,688.30	145,913,462.14
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,480,708,328.26	2,221,882,418.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,173,471,490.07	24,465,514,865.37
1.2.2	Биет бус хөрөнгө	949,992,977.49	969,696,121.94
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	78,905.45	
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,123,543,373.01	25,435,210,987.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,604,251,701.27	27,657,093,405.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	473,763,878.94	715,839,334.48
2.1.1.2	Цалингийн өглөг	11,488,338.19	
2.1.1.3	Татварын өр	434,675,333.63	526,014,348.75
2.1.1.4	НДШ–ийн өглөг		1,107,245.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	239,701,578.39	294,903,978.54
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	49,668,678.03	355,152,850.33
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	625,838.89	140,859.14

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,209,923,646.07	1,893,158,616.24
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	13,124,223.49	
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	13,124,223.49	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,223,047,869.56	1,893,158,616.24
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	9,599,204,499.54	9,599,204,499.54
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	6,940,000.00	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915,919,985.27	2,915,919,985.27
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,000,289,928.90	9,170,006,352.90
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,858,849,418.00	4,078,803,951.41
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	20,381,203,831.71	25,763,934,789.12
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,604,251,701.27	27,657,093,405.36

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,542,448,257.08	9,551,734,378.49
2	Борлуулалтын өртөг	7,011,899,301.09	5,766,452,515.21
3	Нийт ашиг(алдагдал)	1,530,548,955.99	3,785,281,863.28
4	Түрээсийн орлого	2,543,400.00	1,600,168.18
5	Хүүгийн орлого	137,846.29	166,558.16
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	505,403,890.02	735,692,578.78
9	Борлуулалт, маркетингийн зардал	221,381,226.27	1,627,254,807.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,552,856,943.35	1,992,369,527.42
11	Санхүүгийн зардал	56,472,314.90	55,340,412.25
12	Бусад зардал	283,996,474.13	357,872,228.02
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	44,982,547.07	191,915,229.54
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-121,055,413.42	297,988,963.93
19	Орлогын татварын зардал	4,368,891.87	48,990,419.35
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-125,424,305.29	248,998,544.58
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-125,424,305.29	248,998,544.58
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлаг-дсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,599,204,499.54	6,940,000	2,915,919,985.27	4,000,289,928.90	3,858,949,418.00	20,381,303,831.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	9,599,204,499.54	6,940,000	2,915,919,985.27	4,000,289,928.90	3,858,949,418.00	20,381,303,831.71
Залруулсан үлдэгдэл	9,599,204,499.54	6,940,000	2,915,919,985.27	4,000,289,928.90	3,858,949,418.00	20,381,303,831.71
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)						
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	9,599,204,499.54	6,940,000	2,915,919,985.27	4,000,289,928.90	3,858,849,418.00	20,381,203,831.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-29,044,011.17	-29,044,011.17
Залруулсан үлдэгдэл	9,599,204,499.54	6,940,000	2,915,919,985.27	4,000,289,928.90	3,829,805,406.83	20,352,159,820.54
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					248,998,544.58	248,998,544.58
Бусад дэлгэрэнгүй орлого				5,169,716,424.00		5,169,716,424.00
Өмчид гарсан өөрчлөлт		-6,940,000				-6,940,000
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	9,599,204,499.54	00.00	2,915,919,985.27	9,170,006,352.90	4,078,803,951.41	25,763,934,789.12

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,373,288,617.95	9,046,664,762.35
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,759,772,321.34	8,419,518,403.80
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		16,655.86
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	613,516,296.61	627,129,702.69
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,300,557,907.38	9,169,005,749.93
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,421,844,993.14	2,552,065,073.38
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	859,970,190.97	866,003,475.30
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,047,690,680.72	3,339,914,156.44
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	171,689,910.58	137,958,920.44
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	100,107,063.57	110,859,026.33
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	56,472,314.90	55,340,412.25
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	826,056,077.62	864,513,772.42
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	19,217,116.08	6,549,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	797,509,559.80	1,235,801,913.37
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	72,730,710.57	-122,340,987.58
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	137,846.29	166,558.16
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	137,846.29	166,558.16
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	137,846.29	166,558.16

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,696,381,765.31	1,848,602,844.74
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,696,381,765.31	1,848,602,844.74
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,774,984,276.92	1,793,400,444.59
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,767,180,186.92	1,793,400,444.59
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	7,804,090.00	
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-78,602,511.61	55,202,400.15
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-5,733,954.75	-66,972,029.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	160,781,687.14	155,047,732.39
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,047,732.39	88,075,703.12

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.12	Аудитын нэр: “Дарханы Дулааны сүлжээ” ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/37/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Дарханы Дулааны сүлжээ ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй.	-	Албан шаардлага	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
2	Тайлант жилд төлөгдөөгүй авлагын нийт 155,255.1 мянган төгрөгийн 2 авлагын дансанд НБББББ-ын дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй.	62.1	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
3	Авлагын 3 сая төгрөгөөс дээш үлдэгдлийг түүвэрлэн шалгахад 5 байгууллагатай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	19.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
4	Бараа материал худалдан авалт хийхдээ 1 байгууллагаас ибаримтгүй, НӨТ-гүй худалдан авалт хийсэн.	2.4	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
5	Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 2 нэр төрлийн биет бус хөрөнгийг данснаас хасах, дахин үнэлэх арга хэмжээ аваагүй байна.	6.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Лхагважаргал
	НИЙТ ДҮН	90.8			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/142

Улаанбаатар хот

СЭГ - 2020/37/СТА - ТӨХК

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитын зөвлөмжөөр “Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татваруудыг холбогдох хуульд заасан хугацаанд төлж барагдуулах” гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” зарчим, 20 дугаар зүйлийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор” төлнө, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ” гэсэн тус тус заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг арилгах талаар тодорхой ажил хэрэгжүүлэх, зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дарханы Дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Гантуулд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

М.ЭНХТУУЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНТУУЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.